



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.05.01 № 1-1/2106

танай 2018.04.26-ны № ХЭГ/859 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн "Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Ц.НЯМДОРЖ

**08 1467**  
Doc.yam a5.2018



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,  
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.05.10 № 7/2755  
танай 2018.04.26 -ны № ХЕГ/859 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Танай байгууллагын 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн ХЭГ/859 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн эд хөрөнгө шилжүүлэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7-т заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

0 0775



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 05  
сарын 15 өдөр

Дугаар ЗГ-1/99

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Тогтоолын төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



У.ХҮРЭЛСҮХ

001616



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>16</sup> он <sup>05</sup> дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар <sup>201</sup>/993

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН ТАНАА

Тов тогтоолгох тухай

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

004997



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.05.01 № 1-1/2106

танай 2018.04.26-ны № ХТГ/859 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



**ЦЭНЬМДОРЖ**

**08 1467**  
Doc.yam a5.2018



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,  
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.05.10 № 7/2755

танай 2018.04.26 -ны № ХЕГ/859 -Т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, Т  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Танай байгууллагын 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн ХЭГ/859 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7-т заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.




Ч.ХҮРЭЛБААТАР

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:


"Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: "Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ,  
МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**



**Г.ЗАНДАНШАТАР**

**БАТЛАВ,  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**



**Ц.НЯМДОРЖ**

**“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ  
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэрийг Улсын Их Хурал гаргахаар заасны дагуу “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

**1.2.Практик шаардлага**

Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчийн 2012 оны улсын нэгдсэн үзлэг, тооллогын дүнг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан хамт өргөн мэдүүлсэн боловч уг асуудал Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн шийдвэрлэгдээгүй юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн 2016 оны улсын үзлэг, тооллогын дүнгээр төрийн өмчийн зарим эд хөрөнгийн аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх асуудал дахин тавигдаж, төрийн өмчийн зарим эд хөрөнгийг аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэн авах дараах хэрэгцээ, шаардлага гарч байна:

1.Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар төрийн зарим байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд шинээр барилга байгууламж барьж ашиглалтад оруулж, хуучин барилгаа ашиглахгүй болсон. Мөн төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй, шат дамжлагагүй хүргэж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагын хүчин чадал дутагдалтай байгаа бөгөөд үүнийг төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байна.

Иймд төсвийн зардлыг хэмнэх зорилгоор Дархан-Уул, Говь-Алтай аймаг, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Архангай аймгийн Хайрхан сумын нийгмийн даатгалын тасаг, Баянхонгор аймаг дахь Төрийн банкны салбар, Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Ховд аймгийн Шүүхийн тамгын газар, Дархан-Уул аймаг дахь Гаалийн газар, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн



газрын Увс, Дархан-Уул аймаг дахь ашиглалтгүй байгаа болон ашиглалт муутай барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэн авч хүүхдийн цэцэрлэг болон төсвийн зарим байгууллагыг байршуулан ашиглах шаардлага бий болсон;

2.Төсвийн тухай хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиг үүрэг нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт шилжиж аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын хөрөнгө, санхүүгийн тайлан нь Засаг даргын тайланд нэгтгэгдэн, хяналтыг орон нутгаас хэрэгжүүлдэг болсонтой холбогдуулан Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь Байгаль орчны газрын эзэмшилд байгаа хөрөнгийг цогцолбороор нь холбогдох аймгийн өмчид шилжүүлэх шаардлага гарсан. Мөн Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Төв аймаг зэрэг 6 аймгийн Байгаль орчны газрын хөрөнгө орон нутгийн өмчид хамаардаг тул ийнхүү шилжсэнээр бүх аймгийн Байгаль орчны газар орон нутгийн өмчит болох юм.

3.Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоноос Улаанбайшинт дахь шалган нэвтрүүлэх цогцолбор хүртэлх цахилгааны шугам дэд станцын ашиглалт, үйлчилгээг хариуцах мэргэжлийн байгууллага нь орон нутгийн өмчийн байгууллага тул Эрчим хүчний тухай хуулийн дагуу ашиглалт, үйлчилгээг хариуцан, аюулгүй байдлыг хангахын тулд уг цогцолборын эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх нь зүйтэй байна.

4.Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан зарим үл хөдлөх хөрөнгө нь тухайн аймгийн нутаг дэвсгэрийн хүн ам, бизнес эрхлэгч, худалдан авагч, хэрэглэгчдийн тав тухтай нөхцөлийг хангах, эрүүл аюулгүй орчныг бий болгох асуудлыг аймгийн зүгээс зохицуулах, төвлөрсөн сүлжээнд холбогдсон дулаан байранд байрлуулах зэрэг шаардлагын үүднээс баригдсан тул тэдгээрийн хадгалалт хамгаалалт, үйлчилгээ, арчилгаа цэвэрлэгээ, зохицуулалтын асуудлыг тухайн орон нутаг хариуцах нь оновчтой байна. Иймд Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилга, Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтсийн барилга, Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Хүлэмж, зоорины аж ахуй”-н цогцолборын барилгын тухайн орон нутгийн өмчид шилжүүлэх нь зүйтэй байна.

5.Иргэд, хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор нийтийн эзэмшилд зориулан улсын төсвөөс санхүүжүүлэн барьсан зарим үл хөдлөх хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит байгууллагад шилжүүлэх шаардлагатай байна. Үүнд нийслэлийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дугуйн зам, зогсоол, гадна байрлах спорт цогцолбор болон Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын 805 дугаар ангийн эзэмшилд байгаа Алтан-Өлгий дэх оршуулгын газрын цамхагийн болон хамгаалалтын байр хамаарч байна.

6.Байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас болон бусад шалтгаанаар ашиглалтгүй, илүүдэлтэй болсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, төсвийн зардлыг хэмнэж, шинээр хөрөнгө худалдан авахаас зайлсхийх зорилгоор төрийн болон орон нутгийн зарим хөрөнгөд зохицуулалт хийх шаардлага гарч байна. Үүнд: Зарим аймаг дахь татан буугдсан Хөдөлмөрийн хэлтсийн суудлын автомашин, Увс аймгийн “Бизнес инкубатор” төвийн барилга, татан буугдсан Тахарын албаны баривчлах, хорих байр (Завхан аймгийн Цагдаагийн газар ашиглаж байгаа), Орхон, Дархан-Уул аймаг, Нийслэлийн Багануур дүүрэг дэх Үйлдвэрлэл, технологийн паркийн байрыг хэрэгцээт аймаг, орон нутгийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай байгаа болно. Мөн Булган аймгийн Хөдөө

аж ахуйн нэвтрүүлэх төвийн барилга, тээврийн хэрэгсэл, Замын-Үүдийн чөлөөт бүсийн Говь-Сүмбэр аймаг дахь орон сууцны байр (1 орц), "Эгийн голын усан цахилгаан станц" ХХК-ийн суудлын автомашин, Увс аймаг дахь "Баруун бүсийн эрчим хүчний систем" ХК-ийн суудлын автомашин, Өвөрхангай аймгийн Прокурорын газрын суудлын автомашин, Иргэний нисэхийн ерөнхий газрын 6 ширхэг автомашин шилжүүлнэ.

Төрийн өмчийн эд хөрөнгийг сум, дүүргийн өмчид шилжүүлэх нь олон өмчлөгчийг бий болгож, орон нутгийн өмчийн бодлого, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад төрийн нэгдсэн хяналт тавихад хүндрэл учруулдаг тул сум, дүүргийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх нь оновчгүй гэж үзэж тогтоолын төсөлд төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг тусгана.

**Хоёр. Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөд зохицуулалт хийж илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, шинээр хөрөнгө худалдаж авахад зарцуулах төсвийн хөрөнгийг хэмнэх, орон нутагт хэрэгцээтэй байгаа хүүхдийн цэцэрлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авах талаар аймаг, нийслэлээс гаргасан хүсэлтийг шийдвэрлэхээр зорилгоор "Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Тогтоолын төсөл 1 заалттай бөгөөд төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн байршил, хөрөнгө тус бүрийн үнийн дүнг тогтоолын төслийн хавсралтаар батлахаар тогтоолын төсөлд тусгана.

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна:

-эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирна;

-төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ /Ховд, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах боломж бий болно/;

-төрийн байгууллага ажлын байртай болсноор шинээр барилга барихад зарцуулах улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө хэмнэгдэнэ;

-төрийн өмчөөс шилжүүлж авсан барилгыг ашиглан хүүхдийн цэцэрлэг 4-ийг ажиллуулснаар цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн тоо буурна. /Дархан-Уул, Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймагт цэцэрлэг нэмж байгуулан, нийт 350 орчим хүүхдийг цэцэрлэгт хамруулна/;

-Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган орон нутгийн Байгаль орчны газрыг өмчийн хэлбэрийн хувьд ижил болно;

-жигиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих ажлын байр нэмэгдэнэ. /Увс, Ховд, Баян-Өлгий, Дундговь аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын бизнес эрхлэгч, жигиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих боломж бүрдэнэ/.

Мөн эдгээр хөрөнгөтэй дүйцэхүйц хөрөнгийг улсын орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн бий болгох нь зардал их шаардах тул орон нутагт зориулалтаар нь шууд болон засаж сэлбэн ашиглах боломжийг бүрдүүлж, эдийн засгийн хэмнэлт гаргах юм.

Барилга байгууламжийг тухайн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн өмчит байгууллагад хариуцуулан эзэмшүүлснээр данс бүртгэл хөтлөх, ашиглалт үйлчилгээнд хяналт тавих, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэхэд дэмжлэг үзүүлэх давуу талтай юм.

Улсын Их Хурлын тогтоол батлагдан гарсны дараа Дархан-Уул аймгийн төв болон Архангай аймгийн Хайрхан суманд байгаа барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгон өөрчлөх барилгын засварын зардал болон цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах багш ажилчдын цалин хөлс, урсгал зардлыг тооцож орон нутгийн төсөвт тусгах шаардлагатай.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр шинээр байгууллага байгуулах, эсхүл байгууллага дотор шинээр нэгж, алба бий болгох шаардлага үүсэхгүй бөгөөд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмэх зэрэг эдийн засгийн нэмэлт зардал шаардахгүй болно.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан бусад хөрөнгийн хувьд орон нутгийн өмчид шилжсэнээр ашиглалтын зардал нэмэгдэхгүй бөгөөд түрээсийн төлбөрийн зардал буурах юм.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэд орон нутагт ажиллах томилолтын зардлыг тооцон үзэхэд 8.7 сая орчим төгрөг зарцуулах урьдчилсан тооцоолол гарч байна.

**Дөрөв. Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдаж буй байдал, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай санал**

“Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдан гарснаар хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох шаардлага үүсэхгүй болно

## **ТАНИЛЦУУЛГА**

### **Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлд төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрхийг тодорхойлохдоо, 8.1.4-т “төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах” гэж заасан байдаг.

#### **Нэг.Тогтоолын төсөл боловсруулсан зорилго, ач холбогдол**

Төрийн өмчид байгаа илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг хэрэгцээ шаардлагатай байгаа орон нутагт шилжүүлэх хөрөнгийн зохицуулалт хийх, Төсвийн тухай хууль, Эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж, төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлснээр Дархан-Уул, Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймагт цэцэрлэг нэмж байгуулан, нийт 350 орчим хүүхдийг цэцэрлэгт хамруулах, Ховд, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах боломжийг нэмэгдүүлэх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг өмчийн ижил хэлбэрт шилжүүлэх, Увс, Ховд, Баян-Өлгий, Дундговь аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, орон нутаг дахь зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах төдийгүй аймаг, нийслэлийн эдийн засагт багагүй нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

**Хоёр.Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал**

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг зөвхөн Улсын Их Хурлын тогтоолоор шийдвэрлэдэг хуулийн зохицуулалттай болохыг дээр дурдсан билээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн агентлаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төрийн өмчийн эд хөрөнгийн улсын анхны үзлэг, тооллогыг 1997 онд улс орон даяар зохион байгуулж, улмаар 1999 онд аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх 229.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн жагсаалтыг УИХ-ын 29 дүгээр тогтоолоор анх удаа батлуулснаар орон нутгийн өмч бий болсон юм.

Түүнээс хойш Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ноос "Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" УИХ-ын 2001 оны 91, 2002 оны 84, 93, 2004 оны 18, 2007 оны 37, 2009 оны 90, 2010 оны 73 дугаар тогтоолыг тус тус батлуулж, тухай бүр хэрэгжүүлсэн юм. Энэ хугацаанд Улсын Их Хурлын тогтоолоор нийт 8 удаа төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлсэн байна.

1. УИХ-ын 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид (15 аймаг, нийслэлд) нийт 4,965,878.18 мянган төгрөгийн хөрөнгө (Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар (Зооноз)-ын хөрөнгө, дуусаагүй барилга байгууламж)-ийг шилжүүлсэн бөгөөд эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн данс бүртгэлд тусган ашиглах, худалдан борлуулах зэргээр шийдвэрлэсэн байдаг.

2. УИХ-ын 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор Хэнтий аймгийн өмчид "Чандгана" ХК-ийг шилжүүлсэн байна.

3. УИХ-ын 2002 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 93 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (15 аймаг, нийслэлд) нийт 3,847,428.19 мянган төгрөгийн барилга, байгууламжийг шилжүүлсэн бөгөөд эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн данс бүртгэлд тусган усан хангамж, цэцэрлэг яслийн болон бусад зориулалтаар ашигласан байна.

4. УИХ-ын 2004 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (21 аймаг, нийслэлд) нийт 7,746,059.90 мянган төгрөгийн Өрхийн эмнэлгийн барилга, байгууламж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж болон багийн эмчийн мотоцикл зэрэг хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд эдгээр хөрөнгийг орон нутгийн иргэдэд эмнэлгийг үйлчилгээг цаг алдалгүй хүргэхэд ашиглаж байна. Өрхийн эмнэлгийн хөрөнгө нь орон нутгийн өмчид бүртгэлтэй байна.

5. УИХ-ын 2007 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 37 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (8 аймаг, нийслэлд) нийт 1,852,158.32 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн бөгөөд тэдгээрийг холбогдох орон нутгийн өмчит байгууллагын данс бүртгэлд тусган зориулалтын дагуу ашиглаж байна.

6. УИХ-ын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид (9 аймагт) нийт 917,849.73 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн бөгөөд эдгээр барилга байгууламжийг төрийн үйлчилгээ, сум, багийн үйл ажиллагаанд орон нутгийн өмчит байгууллагууд ашиглаж байна.

7. УИХ-ын 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 73 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид (2 аймагт) нийт 1,262,510.8 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлсэн бөгөөд эдгээр барилга байгууламжийг орон нутгийн өмчит байгууллагууд ашиглаж байна.

Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ноос төрийн өмчийн 2012 оны улсын үзлэг, тооллогын дүнтэй хамтатган төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газарт танилцуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал тавигдаж шийдвэрлэгдээгүй болно.

### **Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнгийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг батлан хэрэгжүүлж байна.

Тооллогын дүнгээр гарсан дүгнэлт, зөвлөмжид төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр тусгасныг харгалзан Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг боловсруулсан.

Тооллогын дүнг хавсаргав.

### **“Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтын тухай**

УИХ-ын тогтоолын төслийн хавсралтад холбогдох байгууллагын хүсэлтээр төрийн өмчөөс орон нутгийн өмчид нийт 28,136,741.71 мянган төгрөгийн дараах эд хөрөнгийг шилжүүлэхээр тусгалаа:

- Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг цогцолбороор нь (санхүүгийн тайлангийн 2017.12.31-ний дүнгээр) холбогдох аймгийн өмчид шилжүүлэх;

Монгол Улсын Төсвийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 58 дугаар зүйлийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нь орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт шилжсэн тул Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг үндэслэн дээр дурдсан 15 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг цогцолбороор нь орон нутгийн өмчид шилжүүлэх саналыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд (хуучнаар) ирүүлсэн юм. Эдгээр саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэмжсэн байна. Үлдсэн 6 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь орон нутгийн өмчид байдаг.

- Аймгууд дахь хөдөлмөрийн хэлтэс татан буугдсан тул дансанд нь бүртгэлтэй байсан зарим автомашиныг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Сүмбэр, Дундговь, Дорноговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн өмчид шилжүүлэх;

Эдгээр автомашины ашиглалтыг сайжруулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр автомашин худалдан авахаас татгалзах зорилгоор аймгууд дахь орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн бөгөөд уг асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцээд дэмжсэн болно.

- Архангай аймгийн Хайрхан сум дахь Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар уг барилгын төсөв батлагдаж 2016 онд ашиглалтад орсон бөгөөд зориулалтаар нь ашиглаагүй тул

аймгийн Засаг даргаас 100 хүүхдийн цэцэрлэг болон хүүхэд, залуучуудын хөгжлийн үйл ажиллагаа явуулахаар орон нутагт шилжүүлэн авах хүсэлт гаргасныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 1/1212 дугаар албан бичгээр дэмжсэн байна.

- Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хөдөө, аж ахуйн нэвтрүүлэх төвийн конторын барилга, сургалтын байр, фургон автомашин, гарааш, торон хашаа, банзан хашаа, трактор зэрэг 7 нэр төрлийн хөрөнгө ашиглалтгүй байгаа тул орон нутгийн өмчид шилжүүлэн авах саналыг мөн ирүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1884 дугаар албан бичгээр дэмжсэн болно.

Тус хөрөнгийг шилжүүлж авснаар орон нутгийн хөрөнгөөр сэргээн засварлаж, орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчдийг ажлын байраар хангах, мөн сургалтын байр болгон ашиглана. Булган аймагт хэрэгжиж буй “Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд тус байшинг чацаргана, жимс, жимсгэнэ тариалж байгаа болон түүний үр жимс, түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжид сургалтын чиглэлээр хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ жилээс жимсний мод тариалж хашааг шинэчлэн барьжээ. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын зүгээс дээрх хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэхийг 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 1/212 дугаар албан бичгээр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/1884 дүгээр албан бичгээр тус тус дэмжсэн болно.

- Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилгыг тухайн аймгийн өмчид шилжүүлэх;

Эдгээр аймгийн худалдааны битүү захын барилгыг түшиглэн орон нутгийн өмчит худалдаа, үйлчилгээний төв байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэн, зах дээр худалдаа эрхлэгчид болон үйлчлүүлэгчдэд шаардлага хангасан, ая тухтай орчныг бүрдүүлэхийн тулд орон нутгийн өмчид шилжүүлэн авах хүсэлтийг аймгийн зүгээс тавьсан юм. Эдгээр барилгыг худалдах шийдвэр гарч байсан боловч орон нутгийн болон хувийн бизнес эрхлэгчдийн зүгээс хөрөнгө оруулалт хийсэн байна. Эдгээр захын барилгууд нь өнөөдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дансанд бүртгэлтэй байна.

Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилгын ашиглалтыг сайжруулах зорилгоор барилгын 60 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн худалдааны төвийн зориулалтаар ашиглах, 40 хувийг төрийн мэдэлд үлдээн, “Автотээврийн төв”-ийн зориулалтаар ашиглахаар аймгийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай тохиролцсон байна. Иймд Увс, Ховд аймгийн худалдааны битүү захыг бүхэлд нь, Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилгын 60 хувийг тус тус аймгийн өмчид шилжүүлэхээр тусгалаа.

- Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоноос Улаанбайшинт дахь шалган нэвтрүүлэх цогцолбор хүртэлх 29.7 км урттай, 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 160, 250 кВА-ын хүчин чадал бүхий трансформаторын хамт иж бүрэн дэд станц, шугамыг Баян-Өлгий аймгийн өмчид шилжүүлэх;

Эдгээр шугам, дэд станц нь Гаалийн ерөнхий газрын эзэмшилд байдаг боловч ашиглалт, үйлчилгээг Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар (орон нутгийн өмчит) хариуцдаг тул Баян-Өлгий аймгийн өмчлөлд шилжүүлж, мэргэжлийн байгууллагад эзэмшүүлэхээр тогтоолын төсөлд тусгалаа.

Энэ саналыг Гаалийн ерөнхий газар болон Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Цахилгаан шугам сүлжээний газар тус тус дэмжсэн болно.

- Говь-Сүмбэр аймгийн Баянтал сум дахь орон сууц буюу 105 дугаар байрны 5 дугаар орц нь Замын-Үүдийн чөлөөт бүсийн балансад бүртгэлтэй боловч "Талын илч" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар ашиглаж байгаа тул орон нутгийн өмчид шилжүүлэх;

Говь-Сүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 150, Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/631 дугаар албан бичгээр тус тус шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн.

Замын-Үүдийн чөлөөт бүсийн захирагчийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/72 дугаар албан бичгээр энэхүү барилгыг төрийн бодлогод нийцүүлэн холбогдох шийдвэр гаргаж, бусдад шилжүүлэхэд татгалзах зүйлгүй гэсэн хариу ирүүлсэн.

Замын-Үүдийн чөлөөт бүсийн Ажлын албаны төсөвт дээрх орон сууцтай холбогдон гарах ашиглалтын зардал тусгагдаагүй бөгөөд өөрсдөө ашигладаггүй юм.

Орон нутгийн өмчид шилжүүлэн авснаар энэхүү барилгын 1 дүгээр давхрыг жижиг, дунд бизнес эрхлэгчдийг ажлын байраар хангах, 2 дугаар давхрыг "Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв" болгох, 3 дугаар давхрыг "Талын илч" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын албан конторын зориулалтаар, 4, 5 дугаар давхрыг төрийн албан хаагчид орон сууцны зориулалтаар түрээсээр ашиглуулахаар төлөвлөсөн байна.

- Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт байршилтай, тус аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй сумын Засаг даргын Тамгын газрын хуучин конторын барилгын 1 дүгээр давхрын урд хэсэг буюу 336 м.кв талбай бүхий байрыг Дархан-Уул аймгийн өмчид шилжүүлэх;

Дархан-Уул аймаг дахь Гаалийн газар нь 2011 оноос Зоос банкны барилгыг эзэмших болсноор хуучин барилгыг нь Дархан-Уул аймгийн өмчлөлд шилжүүлэх боломжтой болсон юм. Уг байр нь Дархан сумын Засаг даргын Тамгын газрын хуучин конторын барилгын 1 дүгээр давхрын урд хэсэг бөгөөд одоогийн байдлаар Дархан сумын Засаг даргын Тамгын газар байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. Ийнхүү орон нутагт шилжсэнээр эзэмшиж буй байгууллага буюу Дархан сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэх боломжтой болно.

- Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн болон дотуур байрыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 1/82 дугаар албан бичгээр орон нутгийн өмчид шилжүүлэн авах хүсэлт тавьж, Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 62 дугаар албан бичгээр уг хүсэлтийг дэмжсэн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын



14-ний өдрийн 1/1419 дүгээр албан бичгээр УИХ-ын тогтоолын төсөлд нэмж оруулах санал ирүүлсэн, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 3/1331 дүгээр албан бичгээр саналыг дэмжсэн байна.

Дундговь аймгийн зүгээс уг барилгыг төрийн үйлчилгээний чиглэлээр ажлын байр дутмаг байгаа төрийн байгууллагыг байрлуулан үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна.

- Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 ширхэг автомашиныг орон нутгийн өмчийн Эрүүл мэндийн төв, Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлэхээр, “Эгийн голын усан цахилгаан станц” ХХК-ийн суудлын автомашин (Ланд-70)-ыг Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, Өвөрхангай аймгийн Прокурорын газрын суудлын машин (“Тоёота чейзер”)-ыг Санхүүгийн хяналт, аудитын албанд эзэмшүүлэхээр орон нутгийн өмчид тус тус шилжүүлэх саналыг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 07/а-602 дугаар албан бичгээр, Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 1/369 дүгээр албан бичгээр тус тус ирүүлсэн. Мөн төрийн байгууллага, төсөлд ашиглаж байсан Хьюндай супер азросити автобусыг Архангай аймагт, суудлын автомашин Ланд круйзер 76 (УНУ 56-12)-ыг Говь-Алтай аймагт, суудлын автомашин Ланд круйзер 78 (УНУ 56-05)-ыг Сэлэнгэ аймагт (Хушаат сумын Эмнэлэг) тус тус орон нутгийн өмчид шилжүүлэн авах саналыг ирүүлсэн. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дансанд бүртгэлтэй суудлын автомашиныг Увс аймгийн Засаг даргын Тамгын газар ашиглаж байгаа бөгөөд “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 200 дугаар албан бичгээр аймагт шилжүүлэх саналыг дэмжсэн байна. “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дансанд бүртгэлтэй суудлын автомашин Y-62 (ГАА 95-59)-ныг орон нутгийн өмчид шилжүүлэх саналыг тус компани дэмжсэн байна. Эдгээр автомашиныг орон нутгийн өмчид хүлээн авч шинэ автомашин худалдан авалгүйгээр ашиглах хүсэлт гаргасан тул эд хөрөнгө шилжүүлэх тухай УИХ-ын тогтоолын төсөлд тусгасан.

- Увс аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн байрлаж байсан 2 давхар “Бизнес инкубатор” төвийн барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Уг барилга нь 400.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан бөгөөд “Увс барилга” ХК-иас нэхэмжилж байгаа 70 сая төгрөгийн дутуу санхүүжилтийн асуудлаас шалгаалан бүртгэлд тусгаагүй байгаа. Энэ барилгыг орон нутгийн өмчид хүлээн авч Засаг даргын Тамгын газрын 2 дугаар байр болгон санхүүжилтийн дутууг нөхөж төлөх, байргүй зарим төсвийн байгууллагыг байрлуулах саналыг Увс аймгийн Засаг дарга гаргасан бөгөөд уг асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар дэмжсэн болно.

- Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын конторын барилга /хуучин/-ыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Лабораторийн шинэ барилгыг 2016 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээн авсан бөгөөд хуучин барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэн Боловсрол, соёл, урлагийн газарт эзэмшүүлэх орон нутгийн саналыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2017 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 1/44 дугаар албан бичгээр дэмжсэн байна.

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дугуйн зам, зогсоол, гадна байрлах спорт цогцолбор буюу нийт 5,009,144.4 төгрөгийн хөрөнгийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх;

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дээрх хөрөнгийг улсын төсвийн санхүүжилтээр барьсан бөгөөд нийслэлийн иргэд, хүүхэд, залуучуудад нээлттэй ашиглуулж байгаа тул орон нутгийн өмчид шилжүүлэн “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт хариуцуулах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хуралдаанаар хэлэлцээд дэмжсэн юм.

- Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын 805 дугаар ангийн эзэмшилд байгаа 7813.96 мянган төгрөгийн балансын үнэ бүхий Алтан-Өлгий дэх оршуулгын газрын цамхагийн болон хамгаалалтын байрыг нийслэлийн өмчид шилжүүлэх;

Алтан-Өлгий дэх хүндэтгэлийн оршуулгын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 100 дугаар тогтоолоор Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалтаас хасагдаж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 486 дугаар тушаалаар объектын хамгаалалтыг татан буулгаж “Улаанбаатар нэгтгэл”-ийн захиргаанд хүлээлгэн өгсөн байна. Иймд дээрх хөрөнгийг нийслэлийн өмчид шилжүүлэх саналыг Хууль зүйн яамны 2014 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 4/3530 дугаар албан бичиг болон Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 7/711 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 7/8099 дүгээр албан бичгээр уг асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай гэсэн санал ирүүлсэн.

- Завхан аймгийн Цагдаагийн газрын ашиглаж буй хуучнаар тус аймаг дахь Тахарын албаны 1 давхар барилгыг орон нутгийн өмчид буюу аймгийн Цагдаагийн газрын эзэмшилд шилжүүлэн авах хүсэлтийг аймгийн зүгээс гаргасан. Уг саналыг Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 7/711 дүгээр албан бичгээр дэмжсэн байна.

Тахарын алба татан буугдаж чиг үүрэг нь Цагдаагийн байгууллагад шилжсэн тул баривчлан хорих байрыг хуучин ашиглаж байсан зориулалтаар нь Завхан аймгийн Цагдаагийн газар ашиглаж байна. УИХ-ын шийдвэр гараагүй тул данс бүртгэлдээ тусгах боломж бүрдэхгүй байна.

- Нийслэлийн Багануур дүүрэг, Дархан-Уул, Орхон аймаг дахь Үйлдвэрлэл технологийн паркийн барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх хүсэлт гаргасныг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 03/1390 дугаар албан бичгээр дэмжсэн байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 1-1220 дугаар албан бичгээр дээрх барилгыг 2009 оноос хойш Дархан үйлдвэр технологийн паркийн зориулалтаар ашиглаж байсан, одоогоор ашиглахгүй байгаа тул ашиглалтыг сайжруулах, төвийн дулааны шугамд холбогдоогүй, засвар үйлчилгээ нэмж хийх шаардлага байгаа. “Дархан үйлдвэр технологийн парк” орон нутгийн өмчит

компанид цаашид ашиглуулах төлөвлөгөөтэй байгаа тул шилжүүлэн авах хүсэлт ирүүлжээ.

Орхон аймгийн Эрдэнэт үйлдвэр технологийн паркийн барилга нь 3 давхар барилгын 2 давхрын хэсэг нийт 252 м.кв талбайтай, конторын 8 өрөө, 2 машины гарааштай бөгөөд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны нэр дээр 109 м.кв газрын гэрчилгээ олгогдсон байдаг. Бусад давхар нь хувийн хэвшлийн өмчлөлд байдаг.

Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргын 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 299 дугаар албан бичгээр орон нутгийн өмчид шилжүүлэн авах санал ирүүлсэн

Энэхүү барилгад "Эрдэнэт үйлдвэр технологийн парк" орон нутгийн өмчит ХХК байрлан 10 жил үйл ажиллагаа явуулж байгаа тул зориулалтаар нь орон нутгийн өмчид шилжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд тусгав

Нийслэлийн Багануур дүүрэг дэх Үйлдвэрлэл технологийн паркийн барилгын Хүнс, хөдөө аж ахуйн яам /хуучин нэрээр/ 2008 онд худалдан авсан бөгөөд одоогийн байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтгүй, эвдэрч тоногдсон байдалтай байна.

Багануур дүүргийн "Үйлдвэр технологийн байр" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь уг байранд үйл ажиллагаа явуулдаггүй, түрээсийн байранд байдаг тул дээрх барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэн авч өөрийн хөрөнгөөр засч сэлбэн ашиглах саналыг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/2365 дугаар албан бичигт дээр дурдсан Уул уурхайн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Багануур дүүрэгт байрлах Үйлдвэр технологийн паркийн барилгыг нийслэлийн өмчид шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн байна.

- Сэлэнгэ аймгийн Мандал суманд улсын төсвөөр баригдсан "Хүлэмж, зоорины аж ахуйн цогцолбор"-ыг орон нутгийн өмчид шилжүүлэн авах саналыг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 1/559 дугаар албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тавьсан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1882 дугаар албан бичгээр дэмжсэн байна. Одоогоор цогцолборыг 10 ногоочны бүлэг, 2 хоршоо, "Монгол ногоо" хөтөлбөр, Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэн, Хот тохижилтын газар тус тус ашиглаж байна.

- Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 98 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 292 м.кв талбай бүхий 1 давхар барилгыг орон нутгийн өмчид хүлээн авах хүсэлт тавьсан. Тус аймаг дахь Төрийн банкны салбар нь шинэ байранд орж уг барилга ашиглалтгүй болох үед уг барилгад орон нутгийн зүгээс 38.8 сая төгрөгийн засвар хийж, 75 хүүхэдтэй 9 багш ажилтантай цэцэрлэг ажиллуулж, Төрийн банктай гэрээ байгуулан сарын 1,230.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлсөөр иржээ.

Төрийн банк 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 026/7048 дугаар албан бичгээр уг барилгыг орон нутагт шилжүүлэх саналыг дэмжсэн боловч 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 12/4007 дугаар албан бичгээр орон нутгийн өмчид шилжүүлэхгүй Төрийн банкны хөрөнгө хэвээр үлдээж цэцэрлэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэсэн тухай мэдэгдсэн.

Баянхонгор аймгийн төвд 844 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд орон нутагт цэцэрлэгийн барилга шинээр барихад хөрөнгийн эх үүсвэр хүрэлцээгүй байгаа тул уг барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд тусгасан болно.

• Говь-Алтай аймаг дахь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх авах хүсэлтийг Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1/234 дугаар албан бичгээр Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн байна. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 8/734 дугаар албан бичгээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр баригдсан тул орон нутагт шилжүүлэх боломжгүй гээд өмнө байгуулсан гэрээний дагуу худалдан борлуулах саналтай гэжээ.



Уг барилгыг орон нутагт хүлээн авч цэцэрлэгийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн бөгөөд орон нутагт цэцэрлэг хүрэлцээгүй, төсөв, эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаа тул шинээр цэцэрлэгийн барилга барьж ашиглалт оруулах боломжгүй байдлыг харгалзан үзээд хэдийгээр Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар худалдан борлуулах саналтай ч орон нутгийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд оруулсан болно.

Уг барилгад Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэг 2016 оны 09 дүгээр сараас эхлэн байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 23 багш ажилчидтай, өдрийн 6 бүлэгт Баяншанд, Индэрт багийн гэр хорооллын 2-5 насны нийт 130 гаруй хүүхдийг хүлээн авч сургуулийн өмнөх боловсрол олгон ажиллаж байна.

• Дархан-Уул аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин конторын барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Засаг дарга С.Насанбат 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 1-1757 дугаар албан бичгээр орон нутгийн өмчид авах хүсэлт гаргасан бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд орон нутагт шилжүүлэхийг дэмжсэн юм.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 1/570 дугаар албан бичгээр үлдэгдэл өртгөөр орон нутгийн өмчид худалдан борлуулахад татгалзах зүйлгүй гэсэн хариу ирүүлсэн байна.

Энэхүү барилгыг мөн орон нутагт хүлээн авч цэцэрлэгийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн бөгөөд орон нутагт цэцэрлэг хүрэлцээгүй, төсөв, эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаа тул шинээр цэцэрлэгийн барилга барьж ашиглалт оруулах боломжгүй байдлыг харгалзан үзээд хэдийгээр Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар худалдан борлуулах саналтай ч орон нутгийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд оруулсан болно.

Уг барилга нь анх цэцэрлэгийн зориулалтаар баригдсан бөгөөд барилгыг албан тасалгааны зориулалтаар засварласан байна. Иймд одоо засвар үйлчилгээ хийж цэцэрлэгийн зориулалттай болгоход 140 сая төгрөг шаардлагатай бөгөөд ингэснээр 100 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай болох юм.

- Дарханы "Автотээврийн үндэсний төв"-ийн ашиглалтгүй барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Уг барилга нь 2014 оноос хойш ашиглалтгүй байгаа бөгөөд тус аймгийн Цагдаагийн газрын Замын тасгийн конторын зориулалтаар ашиглахаар санал гаргасныг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ дэмжсэн байна.

- Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Увс аймаг дахь салбарын уурын зуухны ашиглалтгүй барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Увс аймгийн Улаангом сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу хуучин нисэх буудлын зурваст "Түмэндэлгэржав" орон сууцны хороолол барих тул АТҮТ-ийн уурын зуухны барилга хүртэл орон нутгийн хөрөнгө оруулалтаар дулааны шугам татаж уг барилгыг дулаан дамжуулах төв болгон ашиглах боломжтой юм.

- Ховд аймгийн Шүүхийн гараашийн барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх; Уг гараашийг Ховд аймгийн 14 дүгээр цэцэрлэг агуулахын зориулалтаар ашиглаж байгаа тул шилжүүлэн өгөх асуудлыг Шүүхийн байгууллага дэмжсэн болно.

- Завхан, Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-Хорих ангийн эзэмшилд байгаа Цагдан хорих байрыг орон нутгийн өмчид шилжүүлэх;

Завхан, Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-Хорих ангиудын шинэ байр ашиглалтад орж хуучин Цагдан хорин байр ашиглагдахгүй болсон. Завхан, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрууд эдгээр Цагдан хорих байрыг шилжүүлэн авч Эрүүлжүүлэх, баривчлах байрны зориулалтаар ашиглах зайлшгүй шаардлагатай байгаа саналыг уламжилж, Хууль зүй, дотоод хэргийн сайд дэмжсэн байна.

### **Гурав.Тогтоолын төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахтай холбогдуулан орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх санал хүсэлтийг нэг бүрчлэн судалж, хөрөнгө эзэмшиж буй байгууллагын саналыг албан ёсоор авсан. Хөрөнгө эзэмшиж буй байгууллага нь шилжүүлэхийг дэмжсэн хөрөнгийг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхээр тогтоолын төсөлд тусгасан болно.

Харин хөрөнгө эзэмшигч байгууллага нь дэмжээгүй боловч тухайн орон нутгийн иргэдийн нийтийн эрх ашгийг харгалзан зарим хөрөнгийг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхээр тусгасан болно. Мөн орон нутгийн байгууллагаас ирүүлсэн зарим саналыг зохицуулалтын өөр хувилбараар шийдвэрлэх боломжтой байсан тул зохих ёсоор шийдвэрлэсэн болно.

"Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай" тогтоолын төсөлд тусгагдсан хөрөнгийн талаар танилцуулгын хоёр дахь хэсэгт дэлгэрэнгүй тусгав.

### **Дөрөв.Тогтоолын төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн**

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Цахим хэлэлцүүлэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гадна Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Дорнод, Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв,

Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар, иргэдийн төлөөлөл оролцож, давхардсан тоогоор 100 орчим санал гаргасан.

Мөн тогтоолын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд байрлуулж, олон нийтээс санал авсан.

### **Тав. Гадаад орны туршлага**

АНУ, ОХУ зэрэг ихэвчлэн “холбооны” төрийн байгууламжтай улс төрийн, орон нутгийн өмчтэй байдаг. Мөн Хятад, Солонгос зэрэг зарим нэгдмэл улс төрийн, орон нутгийн өмчтэй байх тохиолдол бий. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тухайн асуудлыг зохицуулсан хуулиар, тийм хуульгүй улсын хувьд Иргэний хууль, Компанийн хууль, холбогдох төрийн байгууллагын шийдвэрээр тус тус зохицуулдаг байна.

“Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдийн саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон болно.

“Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төсөл, түүний хавсралт, холбогдох судалгаа, шинжилгээний тайлан, дүгнэлт, саналын товъёог, холбогдох бусад материалыг хавсаргав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ..... дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар  
хот

### **Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай.
- 2.Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийг хувьчлахгүйгээр зориулалтын дагуу ашиглах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд даалгасугай.
3. Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжсэн эд хөрөнгөтэй холбоотойгоор гарах урсгал зардлыг 2018 оны төсөвтөө багтаан шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Улсын Их Хурлын 2018 оны  
 .... дугаар сарын ....-ний өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх  
 эд хөрөнгийн жагсаалт

1. Архангай аймаг

мян.төг

Д/д	Байршил	Шилжүүлэх хөрөнгө	Хөрөнгийн нийт (балансын) үнэ	Зориулалт
1	Хайрхан сум	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилга	1,544,581.00	Хүүхдийн цэцэрлэг
2	Эрдэнэбулган сум	Архангай аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин /Лексус 470/	50,000.00	албан хэрэгцээнд
3	Эрдэнэбулган сум	Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	133,516.82	Байгаль орчин байгаль хамгаалах, аялал жуулчлал
4	Эрдэнэбулган сум	Автобус Хьюндай супер аэросити, 56-73 ДГО	128,500.00	албан хэрэгцээнд
	дүн		<b>1,856,597.82</b>	

2. Баян-Өлгий аймаг

1	Өлгий сум	Худалдааны битүү захын барилгын (60%) хэсэг	1,831,500.00	Худалдааны битүү зах
2	Цагааннуур тосгоноос Улаанбайшинт хүртэл	Цахилгаан дамжуулах агаарын шугам 10 кВ, 29.7 км, 160, 250 кВа-ын дэд станц	484,798.10	цахилгаан дамжуулах
3	Цэнгэл сум	Суудлын автомашин /ИНЕГ-ын "УАЗ-2206", УБИ 09-51)	26,850.00	албан хэрэгцээнд
	дүн		<b>2,343,148.10</b>	



### 3. Баянхонгор аймаг

1	Баянхонгор сум	Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	198,808.56	Байгаль орчин байгаль хамгаалах, аялал жуулчлал
2	Баянхонгор сум	Баянхонгор аймаг дахь Төрийн банкны барилга (хуучин, 292 м.кв)	81,297.74	Хүүхдийн цэцэрлэг
3	Баянговь сум	Суудлын автомашин /ИНЕГ-ын "УАЗ-2206", УБИ 01-56)	26,850.00	албан хэрэгцээнд
4	Баянхонгор сум	Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Хьюндай старекс"	16,000.00	албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>322,956.30</b>	

### 4. Булган аймаг

1	Булган сум	Булган аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	465,692.93	Байгаль орчин, байгаль хамгаалал, аялал жуулчлал
2	Булган сум	Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийн 7 нэрийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл	80,055.00	хөдөө аж ахуйн ололтыг нэвтрүүлэх
	<b>Дүн</b>		<b>545,747.93</b>	

### 5. Говь-Алтай аймаг

1	Есөнбулаг сум	Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	409,193.01	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Есөнбулаг сум	Говь-Алтай аймаг дахь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилга	336,032.80	Хүүхдийн цэцэрлэг
3	Есөнбулаг сум	Суудлын автомашин /ИНЕГ-ын УАЗ-2206, УБИ 01-39)	26,850.00	албан хэрэгцээнд
4	Есөнбулаг сум	Суудлын автомашин Ланд крузер 76, УНУ 56-12	97,900.00	албан хэрэгцээнд
5	Есөнбулаг сум	Суудлын автомашин У-62, ГАА 95-59	90,000.00	албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>959,975.81</b>	

**6. Говь-Сүмбэр аймаг**

1	Сүмбэр сум	Говь-Сүмбэр аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Сузуки грандвистара"	48,900.00	албан хэрэгцээнд
2	Сүмбэр сум	Говь-Сүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	150,646.71	Байгаль орчин, байгаль хамгаалал
3	Баянтал сум	Замын-Үүдийн чөлөөт бүсийн дансанд бүртгэлтэй 105 дугаар байрны 5 дугаар орцны 1-5 дугаар давхрын байр, орон сууц	169,996.00	орон нутгийн өмчит компанийг ажлын байраар хангах
	<b>Дүн</b>		<b>369,542.71</b>	

**7. Дархан-Уул аймаг**

1	Дархан сум	Дархан-Уул аймаг дахь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилга	816,809.48	Хүүхдийн цэцэрлэг
2	Дархан сум	Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын хуучин конторын байр, (336 м.кв2)	143,808.00	Нутгийн захиргааны байгууллагад конторын зориулалтаар
3	Дархан сум	Дархан үйлдвэр технологийн паркийн барилга /756 м.кв, 2 давхар барилга/	168,000.00	Үйлдвэр, технологийн парк
4	Дархан сум	"Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Дархан-Уул аймаг дахь Автотээврийн хэрэгсэл, техник хяналтын төвийн 2 дугаар барилга, хашаа	321,959.50	Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>1,450,576.98</b>	

**8. Дорнод аймаг**

1	Хэрлэн сум	Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	154,849.15	Байгаль орчин, байгаль хамгаалал
	<b>Дүн</b>		<b>154,849.15</b>	

**9. Дундговь аймаг**

1	Сайнцагаан сум	Дорнод аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Лексус 470"	43,000.00	албан хэрэгцээнд
2	Сайнцагаан сум	Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	316,584.10	Байгаль орчин, байгаль хамгаалал
3	Сайнцагаан сум	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн (хуучин) байр, дотуур байр (гуанзны барилга) холбогдох инженерийн шугам сүлжээ	1,505,673.20	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих
	<b>Дүн</b>		<b>1,865,257.30</b>	

**10. Дорноговь аймаг**

1	Сайншанд сум	Дорноговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин /"Прадо 120"	42,000.00	албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>42,000.00</b>	

**11. Завхан аймаг**

1	Улиастай сум	Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	122,342.45	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Улиастай сум	Завхан аймгийн Цагдаагийн газрын ашиглаж буй хуучин Тахарын алба (хуучин нэрээр)-ны 1 давхар барилга	96,360.00	Цагдаагийн байгууллагын албан контор
3	Улиастай сум	Завхан аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байр	226,158.80	Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд
4	Улиастай сум	Завхан аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Ланд крузер 200", 00-06 ЗАН	68,000.00	албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>512,861.25</b>	

### 12. Орхон

1	Орхон аймаг Баян-Өндөр сум	Эрдэнэт Үйлдвэрлэл технологийн паркийн барилга (ХААҮЯ-ны нэр дээр 109 м.кв газартай, 252 м.кв талбайтай)	240,000.00	Үйлдвэрлэл, технологийн парк
2	Орхон аймаг Баян-Өндөр сум	"Эгийн голын усан цахилгаан станц" ХХК-ийн Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв ашиглаж буй суудлын автомашин (Ланд круйзер-70, УНД 81-31)	80,000.00	эмнэлгийн үйлчилгээнд
	<b>Дүн</b>		<b>320,000.00</b>	

### 13. Өвөрхангай аймаг

1	Арвайхээр сум	Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	70,909.10	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Арвайхээр сум	Өвөрхангай аймгийн Прокурорын газрын суудлын машин "Тоёота чейзер" 38-83 ӨВР	10,000.00	албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>80,909.10</b>	<b>0.00</b>

### 14. Өмнөговь аймаг

1	Даланзадгад сум	Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	119,884.63	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Даланзадгад сум	Өмнөговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)- ийн эзэмшиж байсан автомашин "Ланд крузер 100"	43,000.00	албан хэрэгцээнд
3	Гурвантэс	Суудлын автомашин /ИНЕГ-ын "УАЗ-2206", УБИ 31-86)	26,850.00	албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>189,734.63</b>	

### 15. Сүхбаатар аймаг

1	Баруун-Урт сум	Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	47,971.59	Байгаль орчин, байгаль хамгаалал
	<b>Дүн</b>		<b>47,971.59</b>	

**16. Сэлэнгэ аймаг**

1	Сүхбаатар сум	Сэлэнгэ аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Лексус 470"	65,000.00	төрийн үйлчилгээнд
2	Мандал сум	"Хүлэмж, зоорийн аж ахуйн цогцолбор"	2,895,784.71	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх
3	Сүхбаатар сум	Суудлын автомашин /ИНЕГ-ын "УАЗ-2206", УБИ 01-21	26,850.00	төрийн үйлчилгээнд
4	Сүхбаатар сум	Суудлын автомашин Ланд круйзер 78, УНУ 56-05	87,000.00	төрийн үйлчилгээнд
	<b>Дүн</b>		<b>3,074,634.71</b>	

**17. Төв аймаг**

1	Зуунмод сум	Дундговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "форд экспедишн", ДУА 95-99/	44,000.00	төрийн үйлчилгээнд
3	Зуунмод сум	Суудлын автомашин /ИНЕГ-ын УАЗ-2206, УБИ 01-21	26,850.00	төрийн үйлчилгээнд
	<b>Дүн</b>		<b>70,850.00</b>	

**18. Увс аймаг**

1	Улаангом сум	Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	196,123.18	Байгаль орчин, байгаль хамгаалах
2	Улаангом сум	Бизнес инкубатор төвийн барилга	330,000.00	жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх
3	Улаангом сум	Увс аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Ландкрузер 80"	39,900.00	төрийн үйлчилгээнд
4	Улаангом сум	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ХК-ийн эзэмшлийн суудлын автомашин "Ланд круйзер 200"	88,544.40	төрийн үйлчилгээнд
5	Улаангом сум	Худалдааны битүү захын барилга	3,052,500.00	Худалдааны битүү зах
6	Улаангом сум	"Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын Увс аймаг дахь Уурын зуухны барилга	44,475.90	орон нутгийн дэд бүтцийг сайжруулах
	<b>Дүн</b>		<b>3,751,543.48</b>	

### 19. Ховд аймаг

1	Жаргалант сум	Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	53,054.25	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Жаргалант сум	Ховд аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Ландкрузер 100"	44,000.00	төрийн үйлчилгээнд
3	Жаргалант сум	Худалдааны битүү захын барилга	3,663,000.00	Худалдааны битүү зах
4	Жаргалант сум	Мэргэжлийн хяналтын газрын барилга /хуучин/	167,328.00	Албан контор
5	Жаргалант сум	Ховд аймгийн Шүүхийн тамгын газрын эзэмшилд байгаа Хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг агуулахын зориулалтаар ашиглаж буй Гараашийн барилга	2,265.50	Хүүхдийн цэцэрлэгийн агуулах
	<b>Дүн</b>		<b>3,929,647.75</b>	

### 20. Хөвсгөл аймаг

1	Мөрөн сум	Хөвсгөл аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин "Ландкрузер 105"	67,800.00	төрийн үйлчилгээнд
2	Мөрөн сум	Хөвсгөл аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	742,725.49	Байгаль орчин, байгаль хамгаалал
3	Мөрөн сум	Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 443 дугаар хорих ангийн Цагдан хорих байр, хашааны хамт	17,263.60	Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд
	<b>Дүн</b>		<b>827,789.09</b>	

### 21. Хэнтий аймаг

1	Хэрлэн сум	Хэнтий аймгийн Хөдөлмөрийн хэлтэс(хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин /Ландкрузер 105/	68,000.00	төрийн үйлчилгээнд
2	Хэрлэн сум	Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	160,189.66	Байгаль орчин, байгаль хамгаалал
	<b>Дүн</b>		<b>228,189.66</b>	

**22. Нийслэл Улаанбаатар хот**

1	Баянзүрх дүүрэг	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн 2655 км зам, дугуйн зогсоол	3,579,922.10	Нийтийн хэрэгцээнд ашиглах
2	Баянзүрх дүүрэг	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн спорт цогцолбор	1,429,222.30	Нийтийн хэрэгцээнд ашиглах
3	Багануур дүүрэг	Үйлдвэрлэл технологийн паркийн барилга	175,000.00	Үйлдвэрлэл, технологийн парк
4	Баянзүрх дүүрэг	ЦЕГ-ын харьяа 805 дугаар ангийн эзэмшилд байсан эд хөрөнгө	7,813.96	төрийн үйлчилгээнд
	<b>Дүн</b>		<b>5,191,958.36</b>	
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>28,136,741.71</b>	

## **УЛСЫН ИХ ХУРЛЫН “ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдаж нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг зөвшөөрснөөр 1992 оны Иргэний хуульд нийтийн өмчийн төрөл нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байх бөгөөд төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг өмчлөгч байхаар заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д бүх ард түмнийг төлөөлж төрийн өмчийн өмчлөгч нь Улсын Их Хурал, 77 дугаар зүйлийн 77.1-д тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг өмчлөгч нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус байхаар заасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн агентлаг бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төрийн өмчийн эд хөрөнгийн улсын анхны үзлэг, тооллогыг улс орон даяар 1997 онд зохион байгуулж, улмаар анх удаа 1999 онд УИХ-ын 29 дүгээр тогтоолоор аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх 229.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн жагсаалтыг батлуулснаар орон нутгийн өмч бий болсон юм.

Түүнээс хойш Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ноос төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай тогтоолын төслийг боловсруулан УИХ-ын 2001 оны 91, 2002 оны 84, 93, 2004 оны 18, 2007 оны 37, 2009 оны 90, 2010 оны 73 дугаар тогтоолыг батлуулж хэрэгжүүлсэн юм.

Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ноос 2012 оны төрийн өмчийн улсын үзлэг, тооллогын дүнтэй хамтатган төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газарт танилцуулан Улсын Их Хуралд хүргүүлсэн боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал тухайн үед яригдаж шийдвэрлэгдээгүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн 2016 оны улсын үзлэг, тооллогын дүнтэй хамтатган төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай асуудал дахин тавигдсан юм.

**Нэг.Тавигдаж буй асуудал, түүнд хийсэн дүн шинжилгээ, асуудлын мөн чанар, цар хүрээ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлд орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах нэг хэлбэр нь төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж шилжүүлэх гэж заасныг үндэслэн орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авах асуудлыг хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдох байгууллагаас байнга ирүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллага, бусад байгууллагаас төрийн өмчөөс орон нутгийн өмчид



эд хөрөнгө шилжүүлэн авахаар ирүүлсэн хүсэлтийг судалж үзэхэд орон нутагт дараах асуудал үүссэн байна:

-Аймаг, нийслэлд төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэхэд шаардагдах хөрөнгө дутагдалтай, хөрөнгө олж авах санхүүгийн эх үүсвэр хангалтгүй;

-орон нутагт ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь зарим аймагт төрийн өмчид байхад зарим аймагт орон нутгийн өмчид байдаг.

21 аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нар болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс хөрөнгө шилжүүлэн авах хүсэлтийг гаргаж тухайн хөрөнгийг эзэмшиж буй төсвийн байгууллага, албан газар, төрийн өмчит компанид хандсан байна.

Төрөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авах хүсэлтийг нэгтгэн жагсаалт, төсөл боловсруулж үзэхэд тухайн орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байна. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, хөрөнгө шилжүүлэн авах шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон юм. Эдгээр шалтгаан нөхцөлийг судлан хөрөнгө шилжүүлэн авах хүсэлтийг шийдвэрлүүлэх зорилго, шаардлага, цаашдын ашиглалтын ижил төстэй байдлаар нь багцлан дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна:

1. Улсын төсвийн хөрөнгө болон өөрийн хөрөнгө оруулалтаар төрийн зарим байгууллага, албан газар, төрийн өмчит компани шинээр барилга байгууламж барьж ашиглалтад оруулснаас хуучин барилгыг ашиглахгүй болж байна. Нөгөө талд төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай, шат дамжлагагүй хүргэхэд орон нутагт хөрөнгийн хэрэгцээ шаардлага байнга нэмэгдэж байгаа боловч төсвийн хөрөнгөөр бүрэн шийдвэрлэх боломжгүй юм. Иймд төсвийн зардлыг хэмнэх зорилгоор хуучин барилгуудыг засаж сэлбэн ашиглах, зарим шинэ барилгын ашиглалтыг сайжруулах санал гаргаж байна. Үүнд:

Дархан-Уул, Говь-Алтай аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Баянхонгор аймаг дахь Төрийн банкны салбар, Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Дархан-Уул аймаг дахь Гаалийн газар, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Дархан-Уул аймаг дахь салбар тус тус шинэ байранд орж хуучин барилгууд нь ашиглалтгүй болсон.

Дархан-Уул аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Баянхонгор аймаг дахь Төрийн банкны салбарын хуучин барилгыг засварлан хүүхдийн цэцэрлэг байгуулан түрээсээр ашиглаж байна. Говь-Алтай аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилгыг мөн хүүхдийн цэцэрлэг болгон ашиглахаар төлөвлөсөн байна.

Харин Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хуучин барилгыг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор "Бизнес инкубатор" төв болгох, Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хуучин барилгыг тус аймгийн Боловсрол, соёлын газар засвар үйлчилгээ хийж ашиглах санал ирүүлсэн. Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын хуучин барилгад Дархан сумын Засаг даргын Тамгын газар байрлаж үйл ажиллагаа явуулж байна. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Дархан-Уул аймаг дахь

салбарын хуучин барилгыг тус аймгийн Цагдаагийн газрын Замын тасгийн контор болгон ашиглах юм.

Завхан, Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-Хорих ангиудын шинэ байр ашиглалтад орж хуучин Цагдан хорин байр ашиглагдахгүй болсон. Завхан, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрууд эдгээр Цагдан хорих байрыг шилжүүлэн авч Эрүүлжүүлэх, баривчлах байрны зориулалтаар ашиглах зайлшгүй шаардлагатай байгаа тул орон нутгийн өмчид шилжүүлэхээр төсөлд тусгалаа.

2. Төсвийн тухай хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нь орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт шилжиж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хөрөнгө, санхүүгийн тайлан нь Засаг даргын балансад орж, хяналтыг орон нутгаас хэрэгжүүлдэг болсон. Иймд аймгууд дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын эзэмшилд байгаа хөрөнгийг цогцолбороор нь тухайн аймгийн өмчид шилжүүлэх шаардлага гарсан. Үүнд:

Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий гэсэн 15 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө (цогцолбор) орж байна.

Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Төв гэсэн 6 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хөрөнгө нь орон нутгийн өмчид байдаг тул дээр дурдсан 15 аймгийг шилжсэнээр бүх аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар орон нутгийн өмчид байдаг болно.

3. Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоноос Улаанбайшинт дахь шалган нэвтрүүлэх цогцолбор хүртэлх цахилгааны шугам дэд станцын ашиглалт, үйлчилгээг хариуцах мэргэжлийн байгууллага нь орон нутгийн өмчит тул Эрчим хүчний хуулийн дагуу ашиглалт, үйлчилгээг хариуцан, аюулгүй байдлыг хангахын тулд орон нутгийн өмчид шилжүүлэх шаардлага гарч байна.

Энэхүү цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар хариуцан үйл ажиллагаа явуулж байна.

4. Тухайн нутаг дэвсгэрийн иргэд, бизнес эрхлэгчид, худалдан авагчид, хэрэглэгчдийн эрүүл аюулгүй орчинд тав тухтай ажиллах, үйлчлүүлэх нөхцөлийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр баригдсан зарим үл хөдлөх хөрөнгийг тэдгээрийн хадгалалт хамгаалалт, арчилгаа цэвэрлэгээ, зохицуулалт, хэрэглээнээс шалтгаалан орон нутгийн өмчид байлгах нь оновчтой юм. Үүнд:

Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилга, Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтсийн барилга, Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Хүлэмж, зоорины аж ахуй"-н цогцолбор багтаж байна.

Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилгыг улсын төсвөөр барьж байгуулахаас эхлэн захиалагчийн хяналт тавих болон ашиглалтад орсны дараах ашиглалт үйлчилгээг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцаж байна. Тухайлбал: Увс аймагт "Шинэ Улаангом" ОНӨҮГ, Баян-Өлгий аймагт "Жана Өлке" ОНӨҮГ-ыг байгуулан зөвхөн эдгээр захын барилгын ашиглалт

үйлчилгээг хариуцуулсан байна. Эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэн өгснөөр тухайн аймгийн задгай захад үйл ажиллагаа явуулж байсан бизнес эрхлэгч болон үйлчлүүлэгч, хэрэглэгчид тав тухтай, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангасан ажлын байранд ажиллахын зэрэгцээ нэг цэгт олон хэрэглэгчид үйлчлэх боломж бүрдсэн байна. Худалдааны битүү захын барилгыг анх барьж байгуулахад аймгийн захиргаанаас санаачлан бизнес эрхлэгчдийн оролцоог хангах зорилгоор тэдний хөрөнгийг тус барилга доторх павильон барих, газрын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна.

Архангай аймгийн Хайрхан суманд баригдсан Хүүхэд, гэр бүл, хөгжлийн төвийн барилгын хувьд Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө нь батлагдаж 2016 онд ашиглалтад орсон бөгөөд зориулалтаар нь ашиглаагүй, одоогийн байдлаар ашиглалтгүй байгаа тул аймгийн Засаг даргаас 100 хүүхдийн цэцэрлэг болон хүүхэд залуучуудын хөгжлийн үйл ажиллагаа явуулахаар орон нутагт шилжүүлэн авах хүсэлт гаргасан байна.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Хүлэмж, зоорины аж ахуй"-н цогцолборыг 10 ногоочны бүлэг, 2 хоршоо, "Монгол ногоо" хөтөлбөр, Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэн, Хот тохижилтын газар ашиглаж байгаа тул орон нутгийн өмчид авч жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, "Монгол ногоо" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилго тавьсан байна.

5. Иргэд, хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон, тухтай өнгөрүүлэх зорилгоор нийтийн эзэмшилд зориулан улсын төсвөөс санхүүжүүлэн барьсан зарим үл хөдлөх хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит байгууллага нь хариуцах шаардлага гарсан. Үүнд:

Нийслэлийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дугуйн зам, зогсоол, гадна байрлах спорт цогцолбор багтаж байна. Эдгээр хөрөнгө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байна. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дээрх хөрөнгийг өнөөдрийн байдлаар нийслэлийн иргэд, хүүхэд, залуучуудад чөлөөтэй ашиглуулж байгаа бөгөөд "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨҮГ-т хариуцуулан ажиллаж байгаа тул орон нутгийн өмчид шилжүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дэмжсэн юм.

Мөн Алтан-Өлгий дэх оршуулгын газар нь цагдаагийн байгууллагын хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалтаас хасагдсан тул Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын 805 дугаар ангийн эзэмшилд байгаа цамхагийн болон хамгаалалтын байрыг нийслэлийн өмчит "Улаанбаатар нэгтгэл" компанид шилжүүлэн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг хариуцуулах шаардлага үүссэн болно.

6. Зарим байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас ашиглалтгүй, илүүдэлтэй болсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, төсвийн зардлыг хэмнэх зорилгоор шинээр хөрөнгө худалдан авахаас зайлсхийж, байгаа боломж боллоцоог ашиглан хөрөнгийн зохицуулалт хийх шаардлага гарч байна.

Үүнд зарим аймаг дахь татан буугдсан Хөдөлмөрийн хэлтсийн суудлын автомашин, Увс аймгийн "Бизнес инкубатор" төвийн барилга, татан буугдсан Тахарын албаны баривчлан хорих байр (Завхан аймгийн Цагдаагийн газар ашиглаж байгаа), Орхон, Дархан-Уул аймаг, Нийслэлийн Багануур дүүрэг дэх

Үйлдвэрлэл, технологийн паркийн байр, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Увс аймаг дахь салбарын уурын зуухны ашиглалтгүй барилга багтаж байна.

Эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэн авснаар зориулалтаар нь ашиглах юм. Тухайлбал Орхон, Дархан-Уул аймаг, Нийслэлийн Багануур дүүрэг дэх Үйлдвэрлэл технологийн байр нь Хүнс, хөдөө аж ахуйн яам (хуучнаар)-ны дансанд бүртгэлтэй байсан боловч бүтцийн өөрчлөлтөөр Аж үйлдвэрийн яам (хуучнаар)-нд шилжиж, өнөөдрийн байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй боловч сүүлийн 4 жил ашиглаагүй орхисноос хөрөнгийн чанар байдал нь муудсан байна. Гэтэл Орхон, Дархан-Уул аймаг, Нийслэлийн Багануур дүүрэгт Үйлдвэрлэл технологийн парк ОНӨҮГ-ууд байгуулагдан үйл ажиллагаа явуулж, түрээсийн байранд байрлаж байна.

Увс аймгийн Улаангом сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу хуучин нисэх буудлын зурваст "Түмэндэлгэржав" орон сууцны хороолол барих тул АТҮТ-ийн уурын зуухны барилга хүртгэл орон нутгийн хөрөнгө оруулалтаар дулааны шугам татаж уг барилгыг дулаан дамжуулах төв болгон ашиглах боломжтой юм.

Тахарын алба татан буугдаж чиг үүрэг нь Цагдаагийн байгууллагад шилжсэн тул баривчлан хорих байрыг ашиглаж байсан зориулалтаар нь Завхан аймгийн Цагдаагийн газар ашиглаж байгаа боловч УИХ-ын шийдвэр гараагүй тул данс бүртгэлдээ тусгах боломжгүй байна.

Увс аймгийн "Бизнес инкубатор" төвийн барилгад тус аймгийн төсвөөс 80.0 сая төгрөгийн санхүүжилт хийсэн бөгөөд уг барилгыг бүхэлд нь шилжүүлэн авснаар өөрийн барилгагүй төсвийн байгууллагыг байрлуулан Засаг даргын Тамгын газрын 2 дугаар байр болгон ашиглах юм.

7. Төрийн өмчит зарим байгууллагад илүүдэлтэй, ашиглалтгүй байгаа хөрөнгө нь орон нутгийн өмчит байгууллагад хэрэгцээтэй байгааг зохицуулах шаардлага гарсан. Үүнд:

Булган аймгийн Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийн барилга, тээврийн хэрэгсэл, Замын-Үүдийн чөлөөт бүсийн Говь-Сүмбэр аймаг дахь орон сууцны байр (1 орц), Увс аймаг дахь "Баруун бүсийн эрчим хүчний систем" ХК-ийн суудлын автомашин, Өвөрхангай аймгийн Прокурорын газрын суудлын автомашин, Иргэний нисэхийн ерөнхий газрын 6 ширхэг автомашин, Ховд аймгийн Шүүхийн тамгын газрын гараашийн барилга орж байна.

Эдгээр хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлснээр хөрөнгө шинээр худалдаж авах зардлыг хэмнэх бүрдэх бөгөөд Булган, Говь-Сүмбэр аймагт жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжихэд нэмэр болох юм.

Ийнхүү УИХ-ын тогтоолоор 21 аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын өмчид нийт **28,136,741.71** мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэхээр хөрөнгийн жагсаалтыг байршил, үнийн дүнгийн хамт бэлтгэлээ.

#### **Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл**

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авахаар аймаг, орон нутгаас ирсэн хүсэлтийг судалж үзэхэд дараах шалтгаан нөхцөл харагдаж байна:

- Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай байгаа өнөөгийн нөхцөлд шинээр хөрөнгө бий болгох нь зардал их, хугацаа шаарддаг;

- Орон нутгийн зарим байгууллагын байр, талбай, эд хөрөнгийн хүрэлцээ дутмаг;

- Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүрээнд орон нутгийн өмчийн газар хяналт тавих боломж бүрдүүлэх.

Хөрөнгийг орон нутагт шилжүүлснээр гарах үр дүнг тухайн хөрөнгийг ашиглах зардалтай харьцуулах нь ач холбогдол багатай бөгөөд орон нутгийн төсвөөс цаашид ашиглалтын зардлыг хариуцах боломжтой гэдгээ илэрхийлсэн болно.

### **Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго**

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр орон нутгийн зарим байгууллагын байр талбай, хөрөнгийн хүрэлцээ дутмаг болон өмнө дурдсан бусад асуудлыг дараах байдлаар шийдвэрлэх зорилго тавьж байна:

-Дархан-Уул, Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймагт цэцэрлэг нэмж байгуулан, нийт 350 орчим хүүхдийг цэцэрлэгт хамруулах;

-Ховд, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах боломжийг нэмэгдүүлэх;

-Дундговь аймгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих;

-Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган орон нутгийн Байгаль орчны газрыг өмчийн хэлбэрийн хувьд ижил болгох;

-Увс, Ховд, Баян-Өлгий аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих;

-орон нутаг дахь зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах.

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр нутгийн өөрөө удирдах байгууллагын нийгэм, эдийн засгийн чадавхид түлхэц болж, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн зохистой зохицуулалт хийснээр шинээр хөрөнгө худалдаж авахад зарцуулах төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилго тавьж байна.

**Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн зэрэг болон сөрөг талыг харьцуулсан судалгаа**

"Тэг" хувилбар: Энэ хувилбарыг сонгож Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхгүй орхих боломжтой боловч энэ нь орон нутгийн хөрөнгө, эх үүсвэрийн дутагдлыг нөхөх, хөрөнгийн ашиглалт, бүртгэл хяналтыг сайжруулах, төсвийн хэмнэлт, орон нутгийн нийгэм, эдийн засагт түлхэц үзүүлэх зорилгод хүрэх боломжгүй болно.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбар: Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонголт, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхгүй тул энэ хувилбар зорилгод хүрэх арга болж чадахгүй юм.

Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх хувилбар: Зах зээлийн механизмаар буюу татвар, хураамжийн бодлого, лиценз зөвшөөрөл болон квот зэргээр хязгаарлалт тогтоох зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь орон нутгийн өмчид үнэ төлбөргүй хөрөнгө оруулалт хийх, төрийн болон орон нутгийн өмчийн зохистой зохицуулалт хийх боломжгүй тул төслийн зорилго биелэгдэхгүй юм.

Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар: Төрөөс орон нутагт шууд 26.8 тэрбум төгрөгийн мөнгөн дэмжлэгийг үзүүлэх санхүүгийн боломж байхгүй тул энэ хувилбарыг сонгох боломжгүй юм.

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар: Төрөөс гүйцэтгэх тодорхой чиг үүргийг гуравдагч этгээд буюу төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шаардлагагүй тул энэхүү хувилбар нь төслийн хувьд тохиромжгүй юм.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтаар энэхүү төслийг шийдвэр нь зөвхөн УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул захиргааны акт, захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар шийдвэрлэх эрх зүйн боломжгүй юм.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрхэд “төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах” гэж заасан тул Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

### **Дөрөв. Зохицуулалтын хувилбарын үр нөлөө**

Энэхүү нөлөөллийг тандан судлахдаа Хүснэгт 1, 2, 3, 4-т дурдсан суурь асуултуудыг ашигласан бөгөөд тэдгээр хүснэгтийг тус тус хавсаргав.

УИХ-ын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн болно. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх нь дотоодын хууль тогтоомжоор зохицуулагддаг бөгөөд олон улсын гэрээгээр зохицуулагдахгүй болно.

### **Тав. Зохицуулалтын хувилбарыг харьцуулсан дүгнэлт**

Зохицуулалтын хувилбараас сонгож болох “Тэг” хувилбар болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын төслийн зорилгод хүрэх байдал,

зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжид нийцсэн байдал, олон нийтийн цахим хэлэлцүүлэг, хүн, байгаль орчинд үзүүлэх нөлөө зэрэг шалгуур үзүүлэлтээр харьцуулан доорх хүснэгтэд харуулав.

Шалгуур үзүүлэлт	"Тэг" хувилбар	Хууль, тогтоомжийн төсөл боловсруулах
Зорилгод хүрэх байдал	<p><b>Эерэг тал:</b></p> <p><b>Сөрөг тал:</b></p> <p>Хөрөнгө олж авахтай холбоотой 26.8 сая төгрөгийн зардал хэмнэгдэнэ, орон нутгийн эдийн засагт түлхэц үзүүлэх боломжгүй болсноор асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэхгүй.</p>	<p><b>Эерэг тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажлын байр нэмэгдэх;</li> <li>-Төрийн байгууллага ажлын байртай болсноор шинээр барилга барих улсын болон орон нутгийн төсөв хэмнэгдэх;</li> <li>-Шилжүүлж авсан барилгыг ашиглан хүүхдийн цэцэрлэг 4-ийг ажиллуулах боломжтой болж цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн тоо 375-аар буурна;</li> <li>-төрийн өмчийн эд хөрөнгийн зохистой зохицуулалтыг бий болгоно;</li> <li>-Түрээсийн зардал гарахгүй.</li> </ul> <p><b>Сөрөг тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Орон нутгийн өмчид шилжсэн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн ашиглалттай холбоотой /цахилгаан, дулаан, ус, газар, үл хөдлөх хөрөнгийн төлбөр, засварын зардал г.м/ зардал гарна.</li> </ul> <p>Гэхдээ шинээр хөрөнгө олж авснаас бага зардал гарч зорилгод эерэг нөлөө үзүүлж байна.</p>
Зардал, үр өгөөжийн харьцаа	<p><b>Эерэг тал:</b> Улсын төсвөөс хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон 8.7 сая төгрөгийн зардал гарахгүй.</p> <p><b>Сөрөг тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Орон нутгийн нийгэм, эдийн засагт үр ашиггүй;</li> <li>-Төрийн өмчийн илүүдэлтэй болон ашиглалтгүй хөрөнгийн өгөөж буурах, үнэгүйдэх;</li> <li>- Автомашин түрээслэх зардал гарна;</li> <li>-Ажлын байр нэмэгдэж орлого олох боломж алдагдана;</li> <li>- Хөрөнгө шинээр олж авахад илүү өндөр зардал гарна.</li> </ul>	<p><b>Эерэг тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Гарах зардлаас илүү орлого олох боломж нэмэгдэж орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдалд эерэг нөлөөлнө;</li> <li>- Орон нутагт хөрөнгийн ашиглалт нэмэгдэж эдийн засагт өгөөж өгнө;</li> <li>-Бүртгэлээр тавих хяналт сайжирч хөрөнгө эзэнгүйдэх, үнэгүйдэх асуудал үүсэхгүй;</li> <li>- Сум, дүүргээр хяналт шалгалтаар явахад өөрийн тээврийн хэрэгслийг ашигласнаар зардал хэмнэгдэх;</li> <li>-Ажлын байр нэмэгдсэнээр өрхийн амьжиргаа дээшилнэ.</li> </ul> <p><b>Сөрөг тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-УИХ-ын тогтоол батлагдвал хөрөнгө шилжүүлэн хүлээлцэхтэй холбогдон томилолтын зардалд 8.7 сая төгрөг төсвөөс гарна.</li> </ul>
Хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх	<p><b>Сөрөг тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-төрийн өмчөөс үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авах орон нутгийн эрх ашиг биелэгдэхгүйд хүрнэ;</li> <li>-Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч Байгаль орчны газрын хөрөнгө төрд хэвээр үлдэж, орон нутаг хөрөнгө оруулалт хийх, захиран зарцуулах боломжгүй болно;</li> </ul>	<p><b>Эерэг тал:</b> Хууль тогтоомжид нийцнэ.</p>

	– Эрчим хүчний тухай хуулийн дагуу цахилгааны шугамын эзэмшигч хуулийн этгээд аюулгүй байдлыг хангаж мэргэжлийн байгууллагын хувьд уг шугамыг ашиглан хэрэглэгчдийг тасралтгүй , найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах үүрэг бүрэн биелэгдэхгүй.	
Олон нийтийн цахим хэлэлцүүлэг	Орон нутагт үр дүнгүй хувилбар	Эд хөрөнгө шилжсэнээр орон нутгийн эрх, хууль ёсны сонирхолд нийцэх тул үр дүнтэй хувилбар Хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах үр ашигтай тул тогтоолын төслийг дэмжиж саналаа албан бичгээр ирүүлсэн. -эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэн, байгууллагын хүмүүсийн оролцоог хангаж хэлэлцүүлэг явуулахад төслийг бүрэн дэмжсэн.
Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Нөлөө байхгүй.	Хүүхдийн цэцэрлэг 4-ийг ажиллуулах боломжтой болж цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн тоо 375-аар буурна.

### Зургаа. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

АНУ, ОХУ зэрэг ихэвчлэн “холбооны” төрийн байгууламжтай улс төрийн, орон нутгийн өмчтэй байдаг. Мөн Хятад, Солонгос зэрэг зарим нэгдмэл улс төрийн, орон нутгийн өмчтэй байх тохиолдол бий. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тухайн асуудлыг зохицуулсан хуулиар, тийм хуульгүй улсын хувьд Иргэний хууль, Компанийн хууль, холбогдох төрийн байгууллагын шийдвэрээр тус тус зохицуулдаг байна.



## ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
